

ахуйг дэмжих зэрэг төслүүд багтжээ. Хоёр дахь төлөвлөгөөний ерөнхий стратеги нь эдийн засгийн бүтцийг бэхжүүлэхэд чиглэгджээ.

Хөгжлийн гуравдахь төлөвлөгөөний (1972—1976) үндсэн чиглэлүүд нь урьдах хөгжлийн дараачийн алхам болох эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг түргэтгэх, улсын эдийн засгийг тогтворжуулах, барааны хангамжийг сайжруулах, үйлчилгээг сайжруулах, нийгмийн баялгийг шударгаар хуваарилах бодлогыг багтаажээ.

Хөгжлийн дөрөв дэх төлөвлөгөөний (1977—1981) хоёр үндсэн чиглэлд эдийн засгийг сэргээх, байгалийн баялгийг ашиглах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал багтаж байна. Хөгжлийн тав дахь төлөвлөгөөг (1982—1986) хэрэгжүүлэх явцад засгийн газраас үйлдвэр, эдийн засгийн фискаль бодлого, экспорт нэмэгдүүлэх хөшүүргүүдийг ашиглан гадаад худалдааны боломжийг сайжруулах бодлого, Тайландын мөнгөн тэмдэгтийн девальвацийн бодлогыг явуулсан байна.

Ерөнхийдөө Тайланд улсын засгийн газрын төлөвлөлтийн бодлого нь дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий хувийн секторыг бий болгож хүн амын амьжиргааны төвшинг эрс дээшлүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын хувьд бол төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дотооддоо хөрөнгө хуримтлуулж, эдийн засгийн балансын баазыг бүрдүүлэхийн тулд басхүү багагүй хугацааг зарцуулжээ. Жишээлбэл, Тайланд улсын эдийн засгийн эрчимтэй хөгжил 1961 оноос эхэлсэн гэж үздэг боловч гадаадын хөрөнгө оруулалт 1982 оноос л их хэмжээгээр нэмэгдсэнээс үзвэл Тайланд улсад гадаадын хөрөнгө оруулалтыг хангаж чадахуйц эдийн засгийн бааз бий болгоход даруй 20 гаруй жил шаардагдсан байна. Манай улсын эдийн засгийн сэргэлт гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн шалтгаалах болж байгаа үед Тайланд улсын сургамж басхүү нэгийг өгүүлэхийн хажуугаар энэ улсын сэргэн мандалтад эдийн засгийн төлөвлөлтийн гүйцэтгэсэн үүрэг онцгой анхаарал татаж байна.

ХХ ЗУУНЫ

МОНГОЛ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫН АСУУДАЛД

Х. Гүндсамбуу*

Монгол улсын шинэ үндсэн хууль ёсоор манай орны нийгэм-улс төрийн тогтолцоонд ерөнхийлөгчийн засаглал шийдвэрлэх биш хэрнээ чухал учир холбогдолтой юм. Тийм ч учраас ерөнхийлөгчийн засаглал, ялангуяа ерөнхийлөгчийн эрх мэдлийн талаархи сонгогчдын төсөөлөл, санал бодол, үнэлгээ, сэдэл, үнэлэмж баримжааллыг тандан судлах явдал эрдэм судлал-танин мэдэхүйн үүднээс сонирхолтойг харгалзан тус сэтгүүлийн уншигчдын анхааралд «Ерөнхийлөгчийн сонгууль-93» төслийн хүрээнд хийгдсэн цуврал судалгааны дээжээс сонирхуулая.

Шилжилтийн үеийн монгол орны шинэ хуулиудын тод магнай, торгон жолоо болсон Монгол улсын үндсэн хууль батлагдаж, түүнд манай орны нийгэм-улс төрийн шинэ тогтолцоог ерөнхийлөгчийн бус парламентат ёс давамгайлахуйцаар томьёолсон ч ард иргэдийн санал бодол

* Х. Гүндсамбуу-Гүн ухааны дэд доктор

цэгцэрч, зүгширсэн үнэлэмж баримжаалал тогтоогүй байна. Нэг л хэсэгтэй ийм л байхаас өөр аргагүй болов уу? Яагаад гэвэл нэгтэйгүүр нэг хүний буюу хэсэг бүлгийн нэлэнхүй дарангуйллаас дөнгөж мултарч, ардчиллын зах зухаас амсаж суралцаж байна, нөгөөтэйгүүр монгол орон улирах түүхнээ эзэн хаант засаглалыг элээж, өөдөлж уруудсаар ирсэн билээ.

Захиран тушаах системээс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн нийгэм-улс төрийн тогтолцоог ерөнхийлөгчийн, эсвэл парламентын хүчтэй засаглалыг баримжаалан тогтоох уу? гэдэг асуудал нь өнөөдрийн улс төрийн хүчнүүд, намуудын гэхээсээ түүхийн нарийн учир шалтгаантай юм. Миний бодлоор бид өнгөрсөн далан жилд капитализмыг алгасаагүй, харин социалист хаягтай төрийн монопольт феодализмыг байгуулсан бөгөөд түүний засаглал нь Х.Чойбалсангийн нэг хүний, Ю.Цэдэнбалын хэсэг бүлгийн дарангуйлал, хамжлагачлал нь хөдөлмөрийн дэвтрийн өөсэвгүй бичилт, хот, хөдөөгийн иргэний паспортчилал байлаа.

Эртний хүннүгийн Шаньюгийн үед ч, их бага хаадын үед ч, хожмын захиргаадлын үед ч өнгө зүсээ хувирган, улиран залгамжлагдсаар ирсэн нэгэн зүйл бол хаант засаглалын бүтэц юм. Тэр нь «Азийн үйлдвэрийн арга» гэгчийн нэгэн тулгуур багана, амин сүнс мөн. Хаант засаглал бол төрт ёс, тахин шүтэлт, дорнын деспотизмын хам нэгдэл бөгөөд түүнийг өрнө, дорнын орнууд янз бүрээр задаргаанд оруулж, ардчилсан байна.

Өрнө, дорнын улсуудын төр барилтаас зэрвэсхэн ажиглахад бидний дуурайх дуртай болоод байгаа АНУ гэхэд ерөнхийлөгчийн хүчтэй засаглал, Япон, Англи гэхэд бэлэг тэмдгийн хаант засаглал, Азийн барууд гэхэд эхэндээ цэргийн, сүүлдээ иргэний засаглалд шилжиж иржээ. Харин Латин Америк, Африкт, бас Азийн зарим оронд төрийн эргэлтүүд ээлжилсэн байх юм. Тэгэхээр нийгмийг өөрчлөнө гэдэг бол К. Марксынхаар үйлдвэрлэлийн аргыг бус, зарим судлаачдын дэвшүүлж байгаачлан **үндсэн бүтцүүдийг** өөрчлөх явдал мөн бололтой.

Уншигч танд өгүүлийн нэр, сэдвээс жаахан гажиж буй санагдаж мэдэх юм. Үнэн хэрэгтээ тийм биш. Монголын нийгмийг ардчилна гээд парламентат ёсоор, хөгжүүлэх үү? эсвэл, азийн үйлдвэрлэлийн аргаар нөхцөлддөг үндсэн бүтцийн, эвдэгдэхээсээ уламжлан залгамжлагддаг бүтцийн аясыг даган ерөнхийлөгчийн хүчтэй засаглалд аажмаар шилжих үү? гэдгийг сайтар нягтлууштай юм. Үүнд бодох учиг сэтгэх сэжүүр болгон, ерөнхийлөгчийн эрх мэдлийг багцалж сонгогчдыг хэд хэдэн хэв маягт бүлэглэснээ сонирхуулья.

Нэг. Хүчтэй ерөнхийлөгч

Ерөнхийлөгчийн **хүчтэй засаглалыг** баримжаалагчдынхаар бол манай улсын ерөнхийлөгч жирийн нөхцөлд төрийн төдийгүй засгийн тэргүүн бөгөөд парламентыг тараах, улс төрийн нөлөө бүхий намыг удирдах, онцгой тохиолдолд улс орны хэмжээнд бүхэлд нь эсвэл хэсэгчилсэн онц байдал тогтоох эрх мэдэлтэй байвал зохимжтой ажээ. Энэ дөрвөн эрх мэдэл манай улсын үндсэн хуулинд ерөнхийлөгчид олгогдоогүй болохоор мөрөөдлийн буюу хийсвэр хэв шинж гэж нэрлэсэн ч болно.

Таны бодлоор манай улсын ерөнхийлөгчид ямар ямар эрх мэдэл байвал зүгээр вэ? (%)

	Заавал байх	Баймаар л юм	албагүй	хариулаагүй
1. Төр, засгийн тэргүүн	40,2	27,2	29,2	3,8
2. Парлементыг тараах	16,5	33,8	42,0	7,7
3. Нөлөө бүхий намын удирдагч	6,9	14,4	72,6	6,1
4. Онц байдал шууд тогтоох	43,8	35,5	14,7	6,0

Хүснэгтээс харахад бидний сонгон авсан дөрвөн үзүүлэлтийг нэгэн зэрэг сонгосон сонгогчид сайндаа л судалгаанд хамрагдагсдын 6,9 хувиас хэтрэхгүй, нөлөө бүхий намын удирдагч бус тохиолдолд энэ хэв шинжид хамрагсдын хувийн жин 16,5—40,2-ын хооронд хэлбэлзэхээр байна.

Хот, хөдөөд оршин суугч 1000 шахам сонгогчдын дунд хийсэн социологийн судалгааны анхан шатны мэдээллийг компьютерээр бүрэн боловсруулж, энэ бүлэгт багтагсдын нийгмийн хөрөг, паспортын үзүүлэлтийг хараахан тодорхойлоогүй байна. Урьдчилсан тооцоололтоос үзэхэд дээрхи дөрвөн шалгуурыг нэгэн зэрэг сонгосон сонгогчид бүр ч цөөхөн, хувийн жин нь 6,9 хувиас ч бага байна. Харин тэд дотроо «шүтээн» маягийн хийгээд «ажил үйлсийн» хэв шинжийн ерөнхийлөгчийг төсөөлж буй бөгөөд нэгдэх хэв шинжид гол төлөв хижээл насны эрэгтэйчүүд, хоёр дахь хэв шинжийг дээд тусгай боловсролтой, улс төрийн амьдралын учир начирыг гадарладаг хүмүүс харьяалагдаж байгаа бололтой.

Манай сонгогчдын дотор бидний сонгон авсан нэгдүгээр эрэмбийн үзүүлэлтүүдийг дөрвүүлэнг гэхээсээ, өдөр тутмын үйл ажиллагаандаа төр засгийг тэргүүлдэг, шаардлагатай тохиолдолд улс орондоо онц байдал тогтоочихдог ерөнхийлөгчийг баримжаалсан хүмүүс нэлээд хувийг эзэлж буй бөгөөд тэдний нийгмийн бүрэлдэхүүн алаг цоог, өөрөөр хэлбэл нийгмийн янз бүрийн бүлэг давхраанд цөөнгүй тохиолдож байна. Үүнээс ургуулаад бодвол манай хүн амын тодорхой хэсэг нь онцгой хүчтэй бус, харин төр, засгаа зэрэг тэргүүлдэг ерөнхийлөгчийн засаглалыг хүлээн авахад бэлэн байна.

Хоёр. Аядуу ерөнхийлөгч

Ерөнхийлөгчийн аядуу засаглалыг баримжаалагчдынхаар бол манай улсын ерөнхийлөгч нь бүх ард түмнээсээ сонгогддог, парламентаас баталсан хуулинд хориг тавьчихдаг, төрийн далд бодлого, намын гишүүнчлэл бүхий төрийн тэргүүн юм. Энд дурьдсан II эрэмбийн дөрвөн үзүүлэлтийн хоёр нь манай улсын үндсэн хуулинд баталгаажсан, нэг нь намуудын хууль ёсоор түдгэлзэлтэй, нөгөө нь тодорхойгүй болно.

Ерөнхийлөгчийн аядуу засаглалын хэв шинжийг илэрхийлэгч үзүүлэлтүүдийн сонголтыг дараах хүснэгтээс тодорхой үзмүү.

Таны бодлоор манай улсын ерөнхийлөгч ямар, ямар эрх мэдэлтэй байвал зүгээр вэ? (%)

	Заавал байх	Баймаар л юм	албагүй	хариулаагүй
1. Хуулинд хориг тавих	40,0	36,8	20,1	3,1
2. Ард түмнээс шууд сонгогдох	70,2	20,1	72	4,1
3. Намын гишүүнчлэлтэй байх	9,2	13,7	68,3	8,8
4. Төрийн далд бодлоготой байх	41,8	35,0	9,5	2,7

Ерөнхийлөгчийн аядуу засаглалын талаарх манай сонгогчдын санал бодол ихээхэн савлагаатай байна. Тухайлбал ерөнхийлөгчөө бүх ард түмнээрээ сонгоход арван хүн тутмын долоо нь бэлэн мөртлөө ерөнхийлөгч аль нэгэн намын гишүүнчлэлтэй байхыг дөнгөж арван хүний нэг нь дэмжих жишээтэй. Өөрөөр хэлбэл манай сонгогчид сонгуульд оролцох, санал өгөх утгаараа ихээхэн улс төржилттэй, ерөнхийлөгчийн эрх мэдлийг хайрцаглах, ялангуяа улс төрийн намуудын үйл ажиллагаатай холбох дээр тулахлаараа тун их цэрвэлттэй байна. Хүмүүс намчирхахаа больсон явдал 1993 оны ерөнхийлөгчийн сонгуулийн гол онцлог төдийгүй цаашдын улс төрийн амьдралд ноцтой үр дагавар авчирч болзошгүй тун нарийн асуудал юм.

Бид тодорхой утгаар нь манай орны нийгэм-улс төрийн шинэ тогтолцоог монополь эрх бүхий нэг намт төвт тогтолцооноос гаргаж, төр засгаа олон нам нь тойрон түшсэн, олон ургальч үзэл уралдуулсан тогтолцоонд шилжүүлэхийг ойлгож, түүнд хүрэхийг зорьж байна. Гэтэл хүмүүсийн, тэр дундаа намын гишүүдийн намчирхал эрс унасан нь гайхалтай.

Ардчилал хөгжсөн орнуудад улс төрийн намууд улс төрийн тайзнаас зайлаагүй, харин ч ээлжит сонгуулийн явцад аль нэг нь ялалт байгуулж, төр засгийн эрх мэдлийг хуулийн дагуу авч, эрх баригч намын тэнхлэгийг, эсвэл улс төрийн гол хүчнүүдийн эвслийг дагалдуулан төр, засгаа төвхнүүлж байгаа. Энэ бол дэлхий нийтийн, ардчиллын тогтсон жишиг, улс төрийн капиталын бодит ханш юм. Гэтэл манайд болохоор тодорхой хэмжээний намчирхал шалдаа хүртэл унаж, ерөнхийлөгчөө намаас цэвэршүүлэх» хандлага газар авчээ. Түүнийг юугаар тайлбарлах вэ?

90-ээд оны улс төрийн амьдралын нөхцөл байдал, УБХ дахь намуудын төлөөлөлтөөс үүдэн БНМАУ-ын улс төрийн намуудын тухай хуулиар Улсын ерөнхийлөгчөөс эхлээд төр, засгийн гол бөгөөд өндөр албан тушаалд ажиллагчдын намын гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн юм. Энэ нь хэт улс төржилттэй байсан үеийн улс төрийн «халуурлын хэм», «цусны даралтын» хөөрөлтийг хязгаарласан нь эерэг талтай ч аль нэг намын дэмжлэг тусалцаатайгаар тохиолдлын хүмүүс улс төрийн амьдралын тайзанд гарч, албан тушаалын зөөлөн суудалд шигдэх, улмаар дахин хүнд сурталжих шимт хөрс, хүндэтгэх учир шалтгаан болсон билээ. Ерөнхийдөө сүүлийн хэдэн жилд улс төрийн зүтгэлтнүүд гэгч тодорч, дэвших боломж бүрэлдсэн, харин тэдгээрийг эргүүлэн дуудах, огцруулах механизм байхгүй болж, бүхнийг хүний эрхээр хаацайлан бамбайлах болсон юм. Төр, засгийн өндөр албан тушаалтнаас ганц нэг нь огцрохоо зарласан буюу дуудагдсан тал бий, гэхдээ тэднээс албан ёсоор огцроогүй, харин өөрөө нэр төрөө гутаах, эсвэл төрийн алба хашихдаа завхрал гаргасан, булхайлцсанаас олны дэмжлэг аваагүй тохиолдол бий. Бас зарим нь «сүүдэрт» үлджээ.

Зүй зохистой намчирхлаас олон нийт цэрвэж залхах болсон нь улс төрийн үйл явц, нийгэм-улс төрийн шинэ тогтолцоонд эерэгээс гадна сөрөг үүрэг гүйцэтгэж, хохиролтой үр дагаварт хүргэж мэднэ. Өнөөгийн олон орны улс төрийн амьдралд эрийн цээнд хүрсэн улс төрийн намууд даацтай үүрэг гүйцэтгэж, төр засгийг нийгэмтэй, ард түмэнтэй холбож «зөөлөн холбоос» болж байна. Гэтэл манайд зарим тохиолдолд «богино», заримдаа алдарсан холбоосыг үүсгэж байна. Наад захын жишээ хэлэхэд ноднингийн УИХ-ын сонгуулийн хуулийн хуулбар болсон энэ жилийн ерөнхийлөгчийн сонгуулийн хууль нь арга зүй, үзэл баримтлалын хувьдаа ч бүлэг зүйлийн төвшиндөө ч хуулийн сийм-

хийтэй юм. Жишээлэхэд ноднингийн УИХ-ын сонгуулийн хуулинд нэг намын гишүүнийг нөгөө намаас дэвшихийг хориглож байсан бол ерөнхийлөгчийн сонгуулийн хуулинд нэг намаас нэр дэвшээд ялагдсан, манай ард түмний хэлдгээр «шороотой бөх» нөгөө нам юм уу эвслээс нэр дэвших бололцоотой болжээ. Нийгэмд намчирхал саарсан үед ийм байж болох юм гэхэд хамгийн гол нь ерөнхийлөгчид нэр дэвшигч өөрийгөө дэвшүүлэх боломжгүйд хэргийн гацаа оршино. УИХ-ын гишүүдийг бол намаас, бас бие даан өөрийгөө дэвшүүлж болно, харин ерөнхийлөгчид намаас бус, өөрөө өөрийгөө дэвшүүлэх нь зарчмын ач холбогдолтой, ардчиллын гүнзгий агуулгатай юм.

УИХ-д суудалтай нам буюу эвслээс ерөнхийлөгчид нэр дэвшсэн атлаа, намуудын хуулиар тэр нь сонгогдогцмоо намын гишүүнчлэлээсээ түдгэлздэг «хачин» логик бий болсон нь олон түмэн намаас цэрвэх, дайжихын ноцтой шалтгаан болж байна. Нэг талаас ард түмэн, төр засгийн өмнө нэр дэвшигчийн, нөгөө талаас улс төрийн намуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхийн тулд иймэрхүү тасралт, ангал, цоорхойг сайтар бөглөж, ардчиллын хэм хэмжээ, зарчимт шаардлагад нийцүүлэх учиртай. Эс тэгвэл бүр XVIII зууны үед Английн зохиолч Жонатан Свифтын хэлсэнчлэн «улс төрийн нам бол цөөнхийн ашиг сонирхлын төлөө олонхийн ухаангүй явдал» болон хувирна.

Гурав. Ёслолын ерөнхийлөгч

Ерөнхийлөгчийн засаглалын бусад, тухайлбал «бэлгэ тэмдэг-ёслолын», «өглөг буяны», «ид шид-шүтээний» «хос ёсны» гэх мэт хэв маягийн ерөнхийлөгчийг баримжаалагчид бас байна. Эдгээрийг шууд болон дам тодруулахуйц үнэлгээ, санал бодлын байц, тархалт, хувийн жинг доорхи хүснэгтээс харж, дор бүрнээ ургуулан бодох биз ээ.

Таны бодлоор манай улсын ерөнхийлөгчид ямар, ямар эрх мэдэл байвал зүгээр вэ?

	Заавал байх	Баймаар л юм	албагүй	хариулаагүй
1. Зэвсэгт хүчний дээд командлагч байх	36,1	17,5	43,3	4,1
2. Төр шашныг хослон барих	12,1	25,4	56,7	5,7
3. Үзмэрч, төлөгчтэй байх	8,8	21,5	65,3	4,4
4. Сан хөрөнгийн бэлтэй байх	52,8	35,0	9,5	2,7

Ерөнхийлөгчийн засаглал, түүний эрх мэдлийн талаар сонгогчид, хэлбэрээрээ олон янз, төвшин зиндаагаараа өөр, агуулга багтаамжаараа жигд бус үзэл бодолтой байгаа энэ үед шинэ үндсэн хуулийн ерөнхийлөгчийн анхны сонгууль тохиосон нэгэн бодлын бэлэг дэмбэрэлтэй, нөгөө бодлын сонгогдогчоос гэхээсээ сонгогчоос иргэний ухамсар, хариуцлага, эх оронч сэтгэл, улс төрийн мэдрэмж, соёл шаардаж байна.

Нийгэмд улс төржилт, эс улс төржилт, мөн намчирхал, эс намчир хал явагдаж буй бөгөөд нүднээ ил байна. Харин нийгмийн гүнд ямар үзэгдэл, үйл явц өрнөж, ямар хандлагатайг танин мэдэх амаргүй. Миний бодоход «хар хайрцаг»-ны нууц юундаа байна гэвэл манай оронд бидний эргэлзэхээ больсон, дасал болсон ардчилсан хувьсгал түүнтэй зэрэгцэн XX зууны нэрт сэтгэгч К. Ясперийн хэлсэнчлэн «биеэ хүмүүжүүлэх талаар зохих бэлтгэлгүй ард түмэнд гэв гэнэт эрх чөлөө олговол охлократад буюу үймсэн олны засаглалд хүргэдэг» хувьсгал явагдаж байна. Гэтэл бид **зэрэгцсэн хувьсгалын** тухай бага бодож, гэнэ-

хэн ухаарч, харин нийгмийн хувьсгалууд, хувьсгалын эсэргүү явдал ч дараалалт шинжтэйд дасал болжээ.

1993. 5 сар

**МОНГОЛ ОРОНД ТОТАЛИТАР
ДЭГЛЭМ НОЁРХСОН ЗАРИМ
АСУУДАЛ**

А. Жамбал*

I

Тоталитаризм хэмээх улс төрийн дэглэм, ноёрхлын өвөрмөц онцлогтой шинэ хэлбэр нь ХХ зууны 20-иод оны үеэс ЗХУ-д большевикуудын коммунист дэглэм буюу зүүн хэлбэрээр, Итали, Герман зэрэг орнуудад фашизм буюу баруун хэлбэрээр анх үүсэн тогтжээ. Тоталитаризмын - үзэл санаа, үзэл суртлын эх үүсвэр, үндсийг баруун талаас нь Жентиле, Муссолини, Гитлер, Розенберг нар, зүүн талаас нь Л. Троцкий зэрэг зүүн коммунизмын үзэл сурталчид үндэслэн тавьсан гэж судлагчид үздэг байна. Үүний зэрэгцээ зүүн буюу большевик маягийн тоталитаризмын үзэл санаа, үзэл суртлын эх үндэс нь сталинизм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Тоталитаризмын асуудлыг судалдаг дэлхий нийтийн эрдэмтэн мэргэжилтнүүд уг үзэгдлийг авч үзэж шинжлэхдээ үндсэндээ барууны орнуудын, нэн ялангуяа тоталитаризмын судалгааны ихээхэн өв уламжилтай Герман, Америкийн эрдэмтдийн үзэл баримтлал, үнэлэлт дүгнэлтийг онол, арга зүйн үндэс, чиглэл болгодог байна.¹

Тоталитаризмын мөн чанарыг нээн илрүүлж үнэн зөв ухааран ойлгоход улс төрийн дэглэм хэмээх ойлголт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Улс төрийн дэглэм бол тухайн улс орон дахь улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, төр ба иргэний нийгмийн хоорондын харилцааны нийгэм-улс төрийн шинж чанар, төлөв байдал юм. Энэ утгаар үзвэл тоталитаризм бол иргэний нийгэм, бие хүний амьдралыг хүнд сурталт, цэрэгжсэн төр бүхэлд нь хатуу дэглэн захирсан, улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөөг үгүйсгэдэг улс төрийн дарангуй дэглэм юм.

Тоталитаризм чухамдаа ХХ зууны шинэ үзэгдэл бөгөөд тэрээр хүн төрлөхтний түүхэнд гарч ирж ноёрхож байсан улс төрийн дарангуйллын хэрцгий дэглэм (тирания) дур зоргоор дарангуйлах ёс (деспотия), диктатур болон бусад хэлбэрүүдээс хэд хэдэн шинжээрээ ялгардаг. Улс төрийн уламжлалт дарангуй дэглэмүүд өөрийнхөө ноёрхлоо нийгмийн хэвшиж тогтсон уламжлалт байгуулал, хүрээ хязгаарын дотор тогтоон барьдаг бол тоталитаризм нийгмийн тэрхүү уламжлалт байгуулал, эдийн засгийн хэвшил, оюуны уламжлалт соёл, үнэт зүйлсийг эвдэж түүний нуранган дээр цоо шинээр бүтээн босгохыг чухалчилдаг ажээ. Энэ нь ялангуяа зүүн хэлбэрийн тоталитаризм буюу социалист, коммунист дэглэмийн имманент чанар нь болдог байна. Өмнөх үеийн улс төрийн уламжлалт дэглэмүүд хүнийг дарангуйлан ноёрхохдоо түү-

* ШУА-ийн Философи, социологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан